

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дорждэрэм	Дугаар	L132
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Онгон
Төрсөн газар	Онгон	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бударганы хийд, Дэрсэн худгийн хийд, Дөрвөн худгийн хийд, Их булгийн хийд, Өвгөн хурал, Цагаан худгийн хурал	Сүм хийдийн дугаар	СББД 025, СБОН 014, СБОН 017, СБОН 018, СБОН 019, СБОН 016
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Бударганы хийд, Онгон сумын Дэрсэн худгийн хийд, Дөрвөн худгийн хийд, Их булгийн хийд, Өвгөн хурал, Цагаан худгийн хурал

-Танаас Онгон сумын нутаг дэвсгэрт байсан сүм хийдүүдийн талаар асууж лавлах гэж ирлээ. Та аль хийдэд хэдэн настай байхдаа шавилан сууж байсан бэ?

Хийдийн тухайн үеийн байдал, үйл ажиллагаа гээд өөрийн мэдэх, сонссон дуулснаа хэлж өгөөч?

Би ч сүмд шавилан сууж сүйд болоогүй хүн. Ер нь бол очиж байсан уу гэвэл очиж байсан. Би хөдөө гэрээрээ ном заалгаж байсан. Тэгээд яахав дээ, миний багш нэг лам 1937 онд баригдсан. Би хоёр багштай байсан. Хамгийн анхны А заасан багш гадагшаа оргоод явчихсан. Тэр баригдсан багш бол

Хэлмэгдэгсдийн номноос харахад 1937 онд цаазлагдсан байна лээ. Манайх Цагаан худгийн сүмийн дэргэд байсан. Жаахан хүүхэд багшийндаа орж ном заалгана. Багштайгаа айл байсан өглөө орж бурханых нь тоосыг авчихаад бурханд нь 3 мөргөчихөөд тэгээд багш тийшээ суу гэнэ. Багш хойноо зузаан дэвсгэр дээр завилаад суучихна. Би харалдаа нь очоод

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сөгдөж суугаад алгаа хавсраад байж байна. Багш за өчигдөрийнхөө заалгасныг унш гэнэ. Тэгээд өчигдрийнхөө заалгасныг цээжээр уншина.Тэгээд хэдэн хуудас ном зааж өгөөд за энийг маргааш өглөө цээжлээд ир гэнэ. Ингэж заалгаж байсан юм. Тэгээд яахав Цагаан худгийн сүм дээр манайх ойрхон байсан. Хуралд нь суусан. Тэр үед чинь томоогүй хүүхэд байлаа. Нэг хэнгэрэгний ард суугаад хэнгэрэг цохиод цав идчихнэ. Байшинтын хийд дээр очиж нэг сар болсон. Ном заалгана гээд.

-Цагаан худгийн хийд ямар ямар дуган сүмтэй байсан юм бол?

Цогчэн дуган, Сахиусын сүм гээд 3,4 сүм байсан. Цогчэн дуган нь урд

талдаа , Сахиусных нь зүүн хойноо. Сахиусны сүмээр бараг оруулахгүй дээ. Очоод шагайхаар аймаар 2 бурхан ам хамар нь ангайсан тийм догшин сахиустай байсан. Баян-Эрхтийн овоог цагаан худгийн сахиус гэж хүмүүс ярьдаг.Цагаан худагийн хийд овоо олон лам нартай сайхан хуралтай байсан .Би багшийгаа даган Борхын ширээгээс Улаан тойронгоор даваад өвөл ирж нэг шинэлж байсан юм. Том сүм байсан. Хашаа хүрээтэй, өмнөө чийгатай. Эзний мэдээтэй сүм гээд Чийга гэж 2 чулуун дээр мод босгосон Чингисийн түг шиг л юм байсан. Байшинтын хийдийг 1000 шавьтай газар гэдэг байсан.

-Цагаан худаг хэдэн ламтай байсан юм?

Цагаан худаг бас олон ламтай байсан Лам нарыг ч айхтар барьсан. Би нэг очоод байж байсан хадаг шиг толгойтой өндөр хөхөвтөр лам баруун талд эхэнд шиг суусан уншиж байгаа гэдэг хачин. Тэгээд яахав хурал дууссаны дараа энэ хэн гэдэг хүн бэ гэхэд Цагаан худгийн унзад баригдаад тавигдаад ирсэн юм гэж байсан гэж байсан.

-Цагаан худгийн хийд гол Цогчэн дуганаас гадна дацан байсан уу? Чойрын, Манбын ч юм уу?

Тийм юм намайг байхад байгаагүй. Харин Байшинтын хийд Чойртой байсан юм. Би одоо жаахан нэг хэрэмний хаалгаар шагайсан чинь нэг хэдэн банди хүрээлээд суучихсан нэг юм хэлээд давхиж босоод нэгийгээ алгадах юм. Учрыг нь ч ойлгохгүй. Тэгээд би багшаасаа асуулаа. Багш аа, хэдэн банди нар зодолдож байгаа юм уу? гэсэн чойрын ном хаялцаж байгаа нь тэр ээ,миний хүү, мэдэхгүйгээ тэгээд алгачихдаг юм гэж байсан.

Цагаан худгийн сүмд дацан, чойр гээд янз бүрийн юм байгаагүй. Хүүхэд цөөтэй голдуу өвгөжөөр лам нартай байсан.3, 4 хүүхэд тэгээд дандаа том лам нар байсан.

-Ер нь хурж байх үед хэдэн лам байсан бэ?

Барагцаагаар 30-40 лам лав байсан. Хэнгэрэг нь маш том үхрийн ширээр хийсэн хоёр том хэнгэрэг байсан. 5 ханатын тооноос том. Дөрвөн хүүхэд зэрэг цохиж байж дуугаргадаг нүр нүр гэсэн дуутай. Их дуутай хэнгэрэг байсан юм. Энэ ямар учиртай хэнгэрэг вэ гэхээр лам нарын ярьж байгаа нь ухаан нь Байшинтын хийдэд залахаар тэр хоёр хэнгэрэгийг тээгээд явж байтал Цагаан худгийн сүмийн баруун урагш ирээд тэрэг нь эвдрээд явж чадахгүй болсон. Тэгээд үхрийн ширээр хийсэн хэнгэрэг гэдэг юм. Зүгээр нэг хоёр хүүхэд бол цохиод дуугарахгүй. Дөрвөн хүүхэд л цаана нь хоёр, наана нь хоёр цохиж байж дуугаргана. Тийм нэг нүр нүр гэсэн дуутай, хангинасан дүү байхгүй. Тийм хоёр том хэнгэрэгтэй байсан юм. Өөр бүрээч нар, янз бүрийн хөгжимчин лам нар байлаа. Цагаан худгийн сүм чинь бүрээтэй. Их бүрээ. Бүрээч хоёр лам нь ард нь зогсоод хоёр лам нь урагшаа зогсоод үлээдэг байсан юм.

-Цагаан худгийн хийд маань ямар нэртэй байсан юм бэ? Төвдөөр?

Тэрийг мэдэхгүй байна. Хэлж байсан юм. Бүр мартчихаж.

-Хэзээ байгуулагдсан юм бол? Ямар ноёны санаачлагаар, хэзээ бий болсон юм бол? Энэ тухай сонссон дуулсан юм байна уу?

Тэрийг би дуулаагүй. Нэлээн дээр байгуулагдсан сүм шиг байгаа юм. Наана бол биш. Байшинтын хийд ч яахав. Тойрсон нэг суваргатай. Их олон ламтай. Их л олон сүмтэй байсан юм. Чухам хэд байсан юм мэдэхгүй. Шавилаад сууж байгаагаагүй. Ер

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нь очих нь бол очиж л байсан. Байшинтын хийд гэдэг дээр нэг сар болсон юм би. Тэгээд л гэртээ хүрээд ирсэн. Лам нар баригдаад. Сүүлд нь Цагаан худгийн сүмийг буулгаж байна гэж дуулаад би нэг очсон. Буулгачихсан байсан. Хундаамных нь хөх туйпууг зөөгөөд явж байсан.

Цагаан худгийн хийдийн мяндагтан лам нарын нэрийг санаж байна уу та?

Их унзад нь Бархаа Гомбо нэг баригдаад тавигдаж ирээд эргээд баригдаад цаазлуулсан хүн. Цагаан худгийн цанид лам гээд нэг монхордуу хамартай ягаан лам байсан юм. Нэрийг нь мартчихаад байна аа.

-Гавж хүн үү?

Үгүй одоо цанид лам гэдэг нь том л хүнийг хэлдэг байсан юм байна лээ. Жинхэнэ сүмийн толгойлогч л байсан хүн. Би нэг орсон юм аа. Цанид ламд орж мөргө гээд. Тэгэхэд л нэг тийм монхордуу хамартай сайхан цагаан лам сууж байсан. Би одоо нэрийг нь мэдэхгүй байна. Нэрийг нь надад хэлж байсан юм. Ер нь одоо 70 гаран жилийн өмнөх юм болж байна шүү дээ. Тэгэхээр чинь мартажгүй яахав. Ном ч байхгүй. Шашин ч байхгүй болсон юм. Ярих гэснээ мартчихаад сүүлд хэдий хойно дотор орж ирдэг болсон юм.

Их булгийн сүм энэ тэр гэдэг дээр би очоогүй ээ. Дөрвөн худгийн сүм гэдэг бол яахав ганцхан жаахан дөрвөлжин дуган байсан юм. Сүүлд барьсан юм гэсэн. Тэгээд Дөрвөн худгийн сүм чинь ганцхан дуган тэгээд л өвгөн хөгшин хоёр харж байдаг тийм л байсан байгаа юм. Цагийн хурал гээд үе үе лам нар цуглаад нэг хурал хурдаг байсан. Их том сүм байгаагүй. Ханс хурал гээд бас хэдэн банди нар суудаг тийм хурал байсан юм байна. Дэрсэн худаг гэдэг газар л даа. Их булаг байна, Өвгөн хурал байна тэгээд л болж байх шиг байна. Өвгөн хурал гэдэг нь нэг их байшин сүм ч байгаагүй хэдэн гэртэй хэдэн банди нар ээлжээр ном үзэж суудаг тийм л газар байсан юм. Мөн л цагийн хуралтай байсан юм гэсэн. Тэгээд сүүлд нь 30 хэдэн оны үед Өвгөн хурлыг нүүлгэж ирж байгаа нь гэж хоёр гэр бариад баахан бурхан тахил тэгээд хурал хурна гээд мөн эндээс Санжаа гуай, Жамъянцэрэн гуай, Наваансанжаа, Данзанхайдав гуай энэ дөрөв очиж байсан юм. Байшинтын хийдийн жинхэнэ унзад Бархаа Гомбо гэдэг их сайхан дуутай, яралзсан цагаан шүдтэй, өндөр цагаан лам ирж байсан. Хуучны цагийн хуралтай байнгын хэдэн банди нар суудаг гэсэн. Хоёр хад тахидаг байсан гэсэн. Гомбо сахиус, Лхам сахиус Өвгөн хурлын шүтэж байсан сахиус.Одоо бол яг застав дээр. Миний дээдсүүд тэнд байсан тэгээд би тэрийг нэг тахиулъя гээд бодоод байсан. Тэгээд энэ жил тахьсаан. За энэ баруун хойд Баян-Эрхтий гэдэг овоо гэдэг бол эндээс харагдаж байгаа. Цагаан худгийн сүмийн зүүн дээр байгаа. Сүүлд нь сүм тарснаас хойш намайг бага байхад манайхан тахиулж байсан юм. Тэр урд энгэрт нь. Яахав дээ үлдсэн лам нараар тахиулж байсан. Ер нь хур их татдаг газар. Энэ жил ч тахисны дараа бороо орсон. Тэгээд Цагаан худгийн сахиус нь гэдэг юм даа.

-Цагаан худгийг ямар сахиустай гэдэг юм бэ?

Цагаан худгийг чинь Улаан сахиус л гэдэг юм даа. Жамсран сахиус. Тэгээд одоо сахиусаа тахина гээд тусгай тахидаг лам нартай байсан.

-Сахиусаа хэдийд тахидаг байсан бэ?

Зун л тахиж байсан. Зун л нэг гүйж очиход сахиусаа тахиж байгаа гээд хаалга нь онгорхой хэдэн лам нар сууж байсан. Тэгээд л хаалгаар нь нэг харчихаад явсан. Тэр лүү биднийг оруулахгүй шүү дээ. Тэгээд тэр үед чинь айна ч гэж учир байхгүй. Лам нараас багш нараас.Одоогийнхтой адилгүй юм чинь. Тиймэрхүү л байсан юм. Ер нь яахав дээ. Одоо бол хүний эрх чөлөө гээд сүм хийд олноороо байгуулагдаж байна. Эрэгтэй, эмэгтэй ялгаагүй болж. Урьд чинь сүм рүү чинь

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

эмэгтэй хүн ордоггүй байсан. Харцуул хаа ганц нэг орвол ганц нэг том тушаалтай хүмүүс ордог үүдэнд суудаг байсан. Гороо гээд холуур эргэдэг байсан. Эмэгтэй улс бол тэр гороо л эргэнэ. Тэгээд л явна. Тэр сүм мүмд бол орохгүй. Ийм байсан юм. Тогоо шанага барьдаг хүн бол дандаа жасын лам нар байсан. Манз, цавыг бид нараар зөөлгөнө л дөө. Зэс данхтай цайг цалгиулаад л явдаг байсан. Нударгаар гүядуулна. Тэрний чинь дэглэм чанга тийм л байсан юм даа. Өвөө нь нэг ийм л юм ярина. Өөрөөр бол би тэнд шавилж суугаад ном үзэж байсан юм байхгүй. Надад ном зааж байсан багш мөн баригдаад алга болсон.

-Цагаан худгийн хийдийн лам нар ямар ном голчилж үздэг байсан бэ? Чойр, Зурхай, Манбаас алийг нь их голлодог байсан бэ?

Ер нь тэнд чинь Чойрыг их голлодоггүй байх аа. Ер нь хурлынхаа уншлагыг голлодог байсан.

-Хайлан хүрж байсан юм болов уу?

Хүрж байсан юм гэнэ лээ. Би тэрэнд нь суугаагүй.

-Өөр Майдар эргэх, маанийн бүтээл хийх, нүгнээ хүрах ч байдаг юм уу тийм юм болдог байсан уу?

Тийм юм байсан байх аа.

Цам гардаг байсан уу?

Үгүй ээ. Байшинтын хийд цамтай байдаг байсан. Тэр цамыг чинь нэг үзсэн юм. Цагаан худгийн хойд дээр чинь нэг овоо байгаа. Жил бүр тахидаг байсан. Зун нь тахиад морь уралдуулдаг тийм газар байсан юм. Тэр овоо чинь чулуугаар Батцагаанархуу юм бариад тэгээд шохойдчихсон юм. Тэр их л удсан овоо байх ёстой. Тэгээд сүүлдээ байхгүй. Хэдэн чулуу болсон. Тэрийг нь сэргээгээд одоо Баяндэлгэр (сүм) тахидаг юм гэсэн. Манай сүм тэр Баян-Эрхтий гэдэг овоог тахиж байгаа.

-Цагаан худгийн хийд маань өдөр, сар тутмын хуралтай байсан уу?

Лам нар сууж байгаа юм чинь байнгын хуралтай.

-Тэндээс тодорч гарч байсан хувилгаадууд, зохиол бүтээл туурвиж байсан лам нар байгаа юу? Тийм юм ер нь дуулаагүй. Мэдэхгүй юм. Байшинтын хийдийн л лам юм гэнэ лээ. Агваанжамц гээд зурхайч л юм гэсэн. Сүүлд аймагт банкны дарга л их хийсэн. Сайн зурхайч гэдэг байсан юм. Дээр үеийн зурхайч нар чинь хүн юм асууж байхад самбар дээр үнс үрээд үзэг шиг юм бариад нэг баахан тоо бичдэг л байсан. Тэгээд л арилгаад л.

-Олонд их алдаршсан хүн үү?

Сайн зурхайч гэж байсан. Их булаг л жинхэнэ хувилгаантай хийд байсан юм гэнэ лээ.

- Цагаан худагт ном барладаг байсан уу?

Хийдийн хамгийн баруун урд талд Данд өвгөний хашаа гээд байдаг байсан. Үлгэрийн далайг их уншдаг хүн байсан. Тийм өвгөн хар хүн байсан юм. бурхан нь Махгал юм гэсэн. Тэр Цагаан худгийн хийдийн хойно нэг толгой дээр нэг жаахан овоо бий. Тэр нь одоо ямар учиртай байсан юм. Жинжирийн овоо гэж. Цагаан худаг гэдэг чинь хоёр өндөг шиг цагаан чулуу сүмийн чинь баруун урд талын толгойн баруун хажууд байгаа. Манай энэ Цагаан худгийг чинь хангарьд шинжтэй газар гэдэг юм. Цагаан худгийн хоёр цагаан толгойг хоёр өндөг нь гэдэг юм. Зүүн далавч нь Баян-Эрхтий овоо, баруун далавч нь Бадрах.

-Баян-Эрхтий, Бадрахын тахилгын судар сан байдаг уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бадрахын уулынх бол Баяндэлгэрийн лам нарт байдаг юм байна лээ. Баян-Эрхтийнх бол байхгүй. Дандаа Алтан-Овоогоороо тахидаг. Баян-Эрхтийг яагаад Алтан-Овоогоороо тахидаг вэ гэхээр Баян-Эрхтий дээр гарахаар Алтан-Овоо ил байдаг юм. Үндсэн судрууд нь бол байхгүй.

-Цагаан худгийн хийдийн хаагдах нураагдах үеийн тухай? Ямар үйл явдал болсон бэ?

Үгүй яахав дээ. Өнөө лам нар чинь баригдаад. Тэгээд бурхан тахилыг нь авч эхлээд, тэгээд л сүүлдээ сүмийг нь нураасан даа. Цагаан худгийн хийдийн бурхан тахилыг Орос руу аччихсан. Оросууд ирчихсэн дугануудыг нь буулгаж байсан. Тэр үед Орос хүнээс айдаг ч гэж жигтэйхэн байсан. Тэгээд сүүлд нь очиход баахан шохой, дээврийн тоосгоноос өөр юм байхгүй байсан. Тэгээд хамаг юмыг нь зөөгөөд явчихсан байсан. Хундаам нь үлдээд. Тэгээд хундаамыг нь сүүлд нь ухаад хөх туйпууг нь Байшинтын дивизийн цэрэг зөөгөөд одоо тэгээд бүр дор нь дэвссэн чулууг нь ухаад авчихсан байна.

-Хийдийн үйл ажиллагаа хэдэд онд хаагдсан бэ?

1937 онд л бүр хаагдсан гэж бодоод байгаа юм.

-Хаагдсанаас хойш хэр удаж байж дуганыг нь нураасан юм бол?

Тэр их удаагүй. 30 хэдэн ондоо нураагаад аваад явчихсан. Ердөө тэгээд дор нь устгасан шүү. Харин манай Овоон сүмийн дуган чинь 1945 онд намайг цэрэгт очиход дуган нь хэвээрээ байсан. Хилийн цэрэг клуб хийчихсэн, өнөө дээр тааз маазны бүх юм чинь хэвээрээ, цонхны модон тор энэ тэр нь хэвээрээ байсан. Урд талыг нь битүүлээд хойд талд нь хаалга гаргачихсан тэгээд клуб хийчихсэн байсан. 1948 онд би хойшоо Байшинт руу шилжсэн. Тэгэхэд тэр сүм тэр чигээрээ үлдсэн л дээ. Тэгээд л Дарьганга сум очоод л тэр дуганыг буулгаад л устгасан байх. Намайг цэрэгт байхад Батцагааны орой ухаад хаячихсан, хэдэн чулуу л байсан.

-Цагаан худгийн хийдийн жасын тухай?

Жас яахав дээ, хэдэн лам нар ажилладаг. Жасын тогоо гээд нэг том юм байсан. Тэр сүүлдээ яасан юм бол? Манзаа чанадаг байсан юм.

-Жасын мал ахуйн тухай?

Одоо тэрийг мэдэхгүй байна. Малтай л байсан байх. Тэр хураагдсан юм уу, хувь хүн ашигласан уу, тийм л байх. Лам нар баригдаад бурхан тахил хураагдаад устахын алдад л тэр хийдийн чинь жасын мал цуг л устаа даа. Тэрнээс урьд нь лав жасын малыг хурааж авлаа гэсэн юм дуулдаагүй. Жаахан байсан болохоор зэрэг мэдэхгүй байна. Одоо болохоор дуулснаа мартчаад байна.

-Цагаан худгийн хийд ямар хийдүүдтэй холбоотой байсан бэ? Төвд лам нар байсан уу?

Төвд хүн гэж байгаагүй. Ширээт, Их булаг, Овоон сүм гээд бүгд л холбоотой байсан байлгүй. Баяндэлгэрийн Ширээтийн хийдэд лам тогтохоо больчоод Их булгийн хийдийн гүртэн очиж тогтоож өгч байсан гэдэг. Ширээтийн Цагаан лам, Цагаан амбан гэж төвд хүн байсан юм гэсэн. Чамхар гэгээн гэдэг чинь төвд хүн. Их айхтар хүн байсан гэсэн. Хулгай хийгээд араас нь хэсэг улсууд мөрдөж ирээд бариад авч гэнэ. Тэгээд Цагаан амбанд намайг ингэлээ гээд айлтгаатхаарай гэсэн. Одоо энэ Цагаан нуур гэж байгаа яваад л байдаг тэндээ, яваад л байдаг тэндээ л эргээд очдог. Тэгээд бүр ядчихаад хаячихаад явчихсан юм гэнэ лээ. Ширээтийн цагаан амбан, Чамхар гэгээн эд нар ер нь хамаатай л юм шиг байна лээ. Овоон сүмийн гүртэн гэж нэг айхтар шүү гүртэн байсан юм гэж өвгөчүүл ярьдаг байсан. Тэр яасан гэхээр дээр үед урдаас хар цэрэг орж ирээд гүртэнгээ буулгалгүй болохгүй болсон юм гэнэ. Одоо тэр солх гэдгийг уншиж онгодыг нь ирүүлдэг байна л даа. Тэгээд тэрийг нь уншаад торгон хадгаар эрүүгээ заачихна гээд эрүүг нь чангалаад ингэж боогоод тэгсэн сүмийнхээ дуганын цонхоор гараад явчихсан юм гэнэ лээ. Тэгээд ирж байгаа цэрэгтэй түрүүчтэй нь уулзангуутаа сэлмийг нь зангидаад

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

зангидаад хаячихсан гэж байгаа. Тэгж ярьдаг юм хөгшчүүд. Гүртэн гэдэг солх нь ирээд онгодыг нь дуудаж чадвал гүртэн шиг чадалтай хүн байхгүй. Би тэр гүртэн бууж байхыг үзээгүй. Хоёр хүн их хүч гаргаж байж эрүүг нь боодог. Тэр чинь боохгүй бол эрүүгээ заачихдаг гэж байсан. Тэгж хар цэргийг манай Овоон сүмийн гүртэн буугаад сэлмийг нь зангидаж өгөөд буцааж байсан юм гэдэг. Жамсран цорж гэдэг хүн гурван давхар хадгаар боогоод л тэгээд л одоо хувцсаа өмсөөд л чойжин буудаг байсан гэсэн. Буухад улаан шунх буугаад ирнэ. Хүмүүс хадаг мэтийн элдэв дээдийн юмаар арчаад авчихдаг байсан гэсэн.

-Одоо энэ хийдүүдийн сахиус шүтээн, сууж байсан лам нарын тоо зэргээс санаж байгаа, мэдэж байгаа юм юу байна?

Цагаан худаг намайг байхад 30, 40 ламтай байсан. Энэ жижиг сүмүүдээр бол юу байхав ээ, 10-хэд, 10 хэдэн юм байсан юм уу үгүй юу.

-Дэрсэн худгийн хийд бага хийд байсан уу?

Тийм. Цагийн хуралтай бас нэг хэдэн банди нар л ном үзэж байсан юм шиг байна лээ. Цагаан худгийн тэргүүн лам нь цанид лам гэж байсан. Гэртээ ганцаараа. Шавь нар нь л орохоос биш бид бол эрхгүй тийм байсан. Би нэг орж мөргөсөн юм. Нэг л их зузаан олбогон дээр ганцаараа сүүчихсэн тийм лам байсан юм.

-Их бага гэсгүй нь хэн хэн гэдэг хүн байсан бол?

Мэдэхгүй ээ. Гэсгүй л эрээн модоо бариад сууж байсан. Би нэг мэдэхгүй гомбоо айлтгалгүй гараад бие засчихаад ирсэн чинь ороод ирэхлээр бөхийж бай гэсэн. Тэгээд л шийтгүүлж байлаа.

-Ер нь энэ хийдүүд маань барилгын хувьд ямар материалаар барьсан байсан хийдүүд вэ?

Хундаам нь хөх тоосго, дээдэх нь ягаан өнгөтэй юмаар будсан туйпуун барилгууд байсан.

-Хийдүүдийн ойролцоо баюу шатаадаг газар байсан уу?

Цагаан худгийн баюу гээд Баюуны худаг гэж байна ш тээ. Тэрний чинь урагшаа явахаар баруун талд нь баюуны газар байсан. Жинхэнэ сүмийг Хятадууд л барьж байсан юм шүү дээ.

Сайн хүний нэрийг муу хүн

Сайхан сүмийн нүүрийг шаазгай шувуу гэдэг үг байдаг юм. Дээврийнхээ доогуур шувуу баалгахгүй гэж тортой байсан.